



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/620

Булган сум

Г Газрын хэмжээ өөрчлөх тухай Г


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Ганцолмон (ГЖ82021915)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 8 дугаар гудамж 849 тоотод байршилтай 6308005363 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 687 м2 газрыг 878 м2 болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зураглалын дагуу газрын хэмжээг өөрчилсүгэй.

2. Б.Ганцолмонтой газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/323 дугаар захирамжийн Б.Ганцолмонд холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ